ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН КОД:СНАГ-2025/196/НА-СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.


**Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг**
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
**Аудитын менежер: В.Эрдэнэцогт**
Утас: 261885 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn
**Ахлах аудитор: М.Пагамдулам**
Утас: 261628, Цахим хаяг: pagamdulamm@audit.gov.mn
**Ингүүмэл жаргалант аудит ХХК Захирал: Э.Батчимэг**
Утас: 99032916 Цахим хаяг: ij24.audit@gmail.com



Улаанбаатар хот
2025 он

## АГУУЛГА

**1. Хараат бус аудиторын дүгнэлт** ..... 3
**2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл** ..... 6
**3. Санхүүгийн тайлангийн тодруулга** ..... 14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ..... 14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ..... 14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..... 15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 16
**4. Аудитын тайлан** ..... 19
4.1 Ерөнхий зүйл ..... 19
4.2 Материаллаг байдал ..... 19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ..... 19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 21
**5. Аудитын илрүүлэлт** ..... 21
5.1 Албан шаардлага ..... 22
5.2 Зөвлөмж ..... 22
**6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл** ..... 25

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АНУ | Америкийн нэгдсэн улс |
| ДЭМБ | Дэлхийн эрүүл мэндийн байгууллага |
| ЗӨСҮТ | Зоонозын өвчин судлалын үндэсний төв |
| НББББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |
| НӨХГ | Нийслэлийн өмчийн харилцааны газар |
| НӨАТ | Нэмэгдсэн өртгийн албан татвар |
| НҮБ | Нэгдсэн үндэстний байгууллага |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ТУЗ | Төлөөлөн удирдах зөвлөл |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ОХУ | Оросын холбооны улс |
| ХӨСҮТ | Халдварт өвчин судлалын үндэсний төв |
| ЭМДС | Эрүүл мэндийн даатгалын сан |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 07/727

танай ____________-ны №____________-т

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ Б.АМГАЛАНБАЯР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Тухайлбал:

- Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дэргэдэх Эрүүл мэндийн салбарын нөөцөд байгаа бараанаас 567,165.6 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авах үед хугацаа дууссан үндэслэлээр акталсан, мөн төвийн захирлын 2024 оны А/08 дугаар тушаалаар хугацаа дууссан 37,510.9 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг акталж устгасан байна. Энэ нь эм, эмнэлгийн хэрэгслийг хугацаа дуусахаас өмнө эргэлтэд оруулаагүй, хугацаанд нь ашиглах арга хэмжээ аваагүй байна;
- Эдийн засгийн ангилал зөрчиж 29,130.7 мянган төгрөгийн томилолтын зардал, 3,632.1 мянган төгрөгийн интернэтийн төлбөр, 2,041.5 мянган төгрөгийн хэвлэл 195.9 мянган төгрөгийн гаалийн зардлыг тээвэр, шатахуун, мэдээлэл, сурталчилгааны зардал, бусад нийтлэг ажил үйлчилгээний зардлаас төлсөн;

зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтууд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/171

Z:\Yawsan_Bichig\2025\0225 SNAG-73.Docx

1525079648

дүгээр тушаалаар баталсан дүрмийн 4.2, "Эрүүл мэндийн салбарын нөөцийн ашиглалтын хугацаанд хяналт тавих, хугацаа дуусахаас өмнө эргэлтэд оруулах, холбогдох байгууллагуудад шилжүүлэх, хугацаа дууссан нөөцийг актлаж, устгах үйл ажиллагааг Зоонозын өвчин судлалын үндэсний төв холбогдох журмын дагуу зохион байгуулна", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-тай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Эрүүл мэндийн салбарын нөөцийн агуулахаас Эрүүл мэндийн сайдын тушаалаар 7,956,943.5 мянган төгрөгийн бараа материал, тоног төхөөрөмжийг эрүүл мэндийн харьяа байгууллагуудад хуваарилан олгосон байна.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн нийт бараа материалын үлдэгдлийн 58.3 хувь буюу 3,680,415.5 мянган төгрөг нь тусгай зориулалтын материал бөгөөд үүнээс 2,439,415.4 мянган төгрөгийн материал нь эрүүл мэндийн салбарын нөөцийн үлдэгдэл байна. Дээрх нөөцийн зарцуулалтын тайланг эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын дагуу жил бүрийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор гарган Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр журамласан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 89.6 хувийн гүйцэтгэлтэй буюу бүрэн хэрэгжсэн 43, тодорхой үр дүн гарсан ч зорилтот түвшинд хүрээгүй 3, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж эрчимжүүлэх шаардлагатай 2 арга хэмжээ байна.

**Бусад асуудлын хэсэг**

Хүн амын эрүүл мэнд, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, үнэлэх, хариу арга хэмжээг авах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийг батлан 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа бөгөөд тус хуулиар "зоонозын халдвар" гэж мал, амьтан, шавж, мэрэгч, дамжуулагчаас хүнд халдварладаг халдварыг хэлнэ гэж анх удаа тодорхойлсон байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АТА9693 9006109
9023030583

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Мөрийн дугаар | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | **8,495,506,188.66** | **6,311,773,298.11** |
| 35100 | Түүхий эд материал | 7,933,416,436.86 | 5,792,325,584.77 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 6,127,915,911.19 | 3,680,415,534.15 |
| 35130 | Эм,боох материал | 1,805,500,525.67 | 2,111,910,050.62 |
| 35400 | Хангамжийн материал | 562,089,751.80 | 519,447,713.34 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 25,866,980.46 | 11,423,810.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 394,702,974.30 | 392,303,666.30 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 53,329,356.00 | 42,910,541.00 |
| 35440 | Түлш,шатах тослох материал | 10,796,354.28 | 5,822,212.28 |
| 35450 | Барилгын засварын материал | 33,255,222.00 | 30,793,250.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 44,138,864.76 | 36,194,233.76 |
| I | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **8,495,506,188.66** | **6,311,773,298.11** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **14,675,039,405.41** | **13,069,135,841.68** |
| 39200 | Биет хөрөнгө | 13,913,063,405.41 | 12,311,614,841.68 |
| 39201 | Барилга,байгууламж,орон сууц | 9,549,455,969.70 | 9,549,419,569.70 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (800,559,111.50) | (1,005,285,820.30) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 1,881,343,580.80 | 1,847,843,580.80 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (705,433,056.320 | (918,665,914.88) |
| 39205 | Машин,тоног төхөөрөмж (компьютер) | 5,843,319,619.54 | 6,325,852,812.64 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (2,185,470,618.70) | (3,747,420,032.80) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 525,555,567.93 | 530,262,220.31 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (195,371,821.85( | (270,391,573.79) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 446,551.77 | 446,551.77 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (223,275.96( | (446,551.77) |
| 39300 | Биет бус хөрөнгө | 761,976,000.00 | 757,521,000.00 |
| 39301 | Програм хангамж | 36,264,567.10 | 34,514,639.25 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (24,013,317.10) | (26,718,389.25) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 749,724,750.00 | 749,724,750.00 |
| II | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **14,675,039,405.41** | **13,069,135,841.68** |
| III | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **23,170,545,594.07** | **19,380,909,139.79** |
| V | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧИЙН ДҮН** | **23,170,545,594.07** | **19,380,909,139.79** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | **2,698,660,655.49** | **2,698,660,655.49** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 2,698,660,655.49 | 2,698,660,655.49 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | **17,238,177,011.39** | **13,448,540,557.11** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 6,951,385,739.58 | 17,238,177,011.39 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 10,286,791,271.81 | (3,789,636,454.28) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 3,233,707,927.19 | 3,233,707,927.19 |
| | **НИЙТ ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **23,170,545,594.07** | **19,380,909,139.79** |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Балансын зүйл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО** | **17,701,551,959.96** | **12,428,829,849.81** |
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **17,701,551,959.96** | **12,428,829,849.81** |
| | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **13,431,365,154.51** | **7,034,823,692.31** |
| | **Нийтлэг татварын бус орлого** | **13,431,365,154.51** | **7,034,823,692.31** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **13,431,365,154.51** | **7,034,823,692.31** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 87,558,919.50 | 27,875,763.27 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 7,511,705,071.43 | 525,197,094.67 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 5,832,101,163.58 | 6,481,750,834.37 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **4,270,186,805.45** | **5,394,006,157.50** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **3,621,660,700.00** | **4,802,103,635.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,621,660,700.00 | 4,802,103,635.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **648,526,105.45** | **591,902,522.50** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 536,915,075.45 | 440,816,777.50 |
| | ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,075,500.00 | 8,075,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 89,843,080.00 | 23,634,245.00 |
| | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 20,692,450.00 | 119,376,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **6,590,612,945.61** | **8,246,183,588.57** |
| | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **6,590,612,945.61** | **8,246,183,588.57** |
| | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **6,590,612,945.61** | **8,246,183,588.57** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **6,178,246,529.48** | **7,727,341,966.81** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал** | **2,342,764,644.22** | **3,028,581,376.14** |
| 210101 | Үндсэн цалин | 1,309,261,359.18 | 1,672,340,987.82 |
| 210102 | Нэмэгдэл | 766,768,662.27 | 1,013,816,908.32 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 100,244,500.00 | 121,654,000.00 |
| 210104 | Урамшуулал | 166,490,122.77 | 220,769,480.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **319,533,165.58** | **400,192,895.03** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 203,661,027.21 | 261,000,038.94 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 23,941,592.89 | 29,891,874.03 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 42,027,029.35 | 40,219,541.01 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,525,571.91 | 13,424,137.58 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 45,377,944.22 | 55,657,303.47 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **133,771,270.00** | **143,646,453.71** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 60,252,183.50 | 63,879,275.20 |
| 210302 | Түлш, халаалт | 52,315,638.18 | 52,208,263.51 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,561,448.32 | 18,438,915.00 |
| 210304 | Байрны түрээс | 11,642,000.00 | 9,120,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **268,878,663.01** | **712,879,648.46** |
| 210401 | Бичиг хэрэг | 23,711,076.00 | 29,962,070.46 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 101,587,394.00 | 109,025,657.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 14,662,597.06 | 12,817,290.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 18,367,300.00 | 16,040,631.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 185,000.00 | - |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | - | 1,320,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 110,365,295.95 | 543,714,000.00 |
| **2105** | **Нормативд зардал** | **531,197,172.00** | **863,784,797.35** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 494,809,524.00 | 835,560,351.85 |
| 210502 | Хоол, хүнс | 36,387,648.00 | 27,111,437.50 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 1,113,008.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **63,861,244.70** | **57,836,887.00** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 930,800.00 | 2,039,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 62,930,444.70 | 55,797,287.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **177,202,113.00** | **190,825,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 177,202,113.00 | 190,825,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **35,949,926.00** | **20,648,808.17** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 19,470,600.00 | 195,872.17 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,500,000.00 | 5,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,470,465.00 | 1,488,375.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,447,320.00 | 1,506,920.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 172,500.00 | 363,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,702,400.00 | 5,414,100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 6,325,441.00 | 6,265,941.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 861,200.00 | 414,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **2,305,088,330.97** | **2,308,946,100.95** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 131,360,848.26 | 159,290,709.26 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 49,970,000.00 | 30,900,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 2,123,757,482.71 | 2,118,755,391.69 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **412,366,416.13** | **518,841,621.76** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **246,474,686.00** | **211,739,634.73** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 212,624,686.00 | 204,185,634.73 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 33,850,000.00 | 7,554,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **164,364,621.58** | **304,822,955.30** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 164,364,621.58 | 304,822,955.30 |
| | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **1,527,108.55** | **2,279,031.73** |
| 213305 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,527,108.55 | 2,279,031.73 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН** | **11,110,939,014.35** | **4,182,646,261.24** |
| **14** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | **-** | **15,000.00** |
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | **-** | **15,000.00** |
| | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз | - | 15,000.00 |
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **9,059,172,105.21** | **7,972,297,715.52** |
| | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 15,354,166.71 |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал | 824,147,742.54 | 7,956,943,548.81 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН** | **10,286,791,271.81** | **(7,972,282,715.52)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **10,286,791,271.81** | **(3,789,636,454.28)** |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **4,357,745,724.95** | **5,421,896,920.77** |
| **I** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **87,558,919.50** | **27,890,763.27** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **87,558,919.50** | **27,890,763.27** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **87,558,919.50** | **27,890,763.27** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 87,558,919.50 | 27,890,763.27 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | **4,270,186,805.45** | **5,394,006,157.50** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,621,660,700.00** | **4,802,103,635.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 3,621,660,700.00 | 4,802,103,635.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | **648,526,105.45** | **591,902,522.50** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 600,515,075.45 | 440,816,777.50 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,075,500.00 | 8,075,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 26,243,080.00 | 23,634,245.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 20,692,450.00 | 119,376,000.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **4,311,098,824.95** | **5,418,888,020.77** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,311,098,824.95** | **5,418,888,020.77** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,898,732,408.82** | **4,900,046,399.01** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал** | **2,342,800,752.13** | **3,031,641,992.39** |
| 210101 | Үндсэн цалин | 1,312,268,559.26 | 1,638,876,449.61 |
| 210102 | Нэмэгдэл | 758,460,784.57 | 1,051,490,349.08 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 103,330,797.97 | 121,946,506.49 |
| 210104 | Урамшуулал | 168,740,610.33 | 219,328,687.21 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **319,497,057.67** | **397,132,278.78** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 210,317,846.87 | 274,631,559.23 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 22,384,822.22 | 31,424,158.26 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 38,623,502.98 | 19,505,404.61 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,379,089.62 | 14,991,291.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 43,791,795.98 | 56,579,865.68 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **133,771,270.00** | **143,646,453.71** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 60,252,183.50 | 63,879,275.20 |
| 210302 | Түлш, халаалт | 52,315,638.18 | 52,208,263.51 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,561,448.32 | 18,438,915.00 |
| 210304 | Байрны түрээс | 11,642,000.00 | 9,120,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **132,345,833.06** | **123,248,005.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 6,732,560.00 | 7,763,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 102,570,976.00 | 104,051,515.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 14,662,597.06 | 3,337,290.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 8,194,700.00 | 8,096,000.00 |
| 210406 | Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс | 185,000.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | **505,872,342.00** | **740,521,351.70** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 455,107,094.00 | 686,362,414.20 |

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 36,387,648.00 | 40,065,937.50 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 14,377,600.00 | 14,093,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **65,596,666.70** | **44,956,100.00** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 2,071,000.00 | 2,039,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 63,525,666.70 | 42,916,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **177,202,113.00** | **190,825,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 177,202,113.00 | 190,825,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **36,335,950.00** | **21,404,508.17** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 19,529,024.00 | 195,872.17 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,500,000.00 | 5,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,470,465.00 | 1,488,375.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,447,320.00 | 1,506,920.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 172,500.00 | 363,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,702,400.00 | 5,414,100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 6,325,441.00 | 6,265,941.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,188,800.00 | 1,170,300.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **185,310,424.26** | **206,670,709.26** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 135,340,424.26 | 175,770,709.26 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 49,970,000.00 | 30,900,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **412,366,416.13** | **518,841,621.76** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **246,474,686.00** | **211,739,634.73** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 212,624,686.00 | 204,185,634.73 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 33,850,000.00 | 7,554,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **164,364,621.58** | **304,822,955.30** |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 164,364,621.58 | 304,822,955.30 |
| 213305 | Төвлөрүүлэх шилжүүлэг-Нэмэлт | 1,527,108.55 | 2,279,031.73 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **46,646,900.00** | **3,008,900.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | **46,646,900.00** | **3,008,900.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **46,646,900.00** | **3,008,900.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | **46,646,900.00** | **3,008,900.00** |
| 222001 | Техник хэрэгсэл,багаж тоног төхөөрөмж | 46,646,900.00 | 3,008,900.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(46,646,900.00)** | **(3,008,900.00)** |
| **IX** | **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **-** |
| **X** | **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **-** |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл** | **2,698,660,655.49** | **3,233,707,927.19** | **6,951,385,739.58** | **12,883,754,322.26** |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | |
|---|---|---|---|---|
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,698,660,655.49 | 3,233,707,927.19 | 6,951,385,739.58 | **12,883,754,322.26** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 10,286,791,271.81 | **10,286,791,271.81** |
| **2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл** | **2,698,660,655.49** | **3,233,707,927.19** | **17,238,177,011.39** | **23,170,545,594.07** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,698,660,655.49 | 3,233,707,927.19 | 17,238,177,011.39 | **23,170,545,594.07** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (3,789,636,454.28) | **(3,789,636,454.28)** |
| **2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл** | **2,698,660,655.49** | **3,233,707,927.19** | **13,448,540,557.11** | **19,380,909,139.79** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2.1** | **НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН** | **4,851,253,900.00** | **4,525,171,442.97** | **326,082,457.03** | **93.3** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **4,614,995,500.00** | **4,313,431,808.24** | **301,563,691.76** | **93.5** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **4,614,995,500.00** | **4,313,431,808.24** | **301,563,691.76** | **93.5** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл суутгал** | **3,047,138,200.00** | **2,903,636,950.24** | **143,501,249.76** | **95.3** |
| 210101 | Үндсэн цалин | 1,701,679,100.00 | 1,619,031,503.46 | 82,647,596.54 | **95.1** |
| 210102 | Нэмэгдэл цалин | 1,011,615,600.00 | 943,330,253.08 | 68,285,346.92 | **93.2** |
| 210103 | Унаа хоолны нэмэгдэл | 114,701,000.00 | 121,946,506.49 | (7,245,506.49) | **106.3** |
| 210104 | Урамшуулал | 219,142,500.00 | 219,328,687.21 | (186,187.21) | **100.1** |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **414,985,300.00** | **380,196,932.66** | **34,788,367.34** | **91.6** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 265,037,700.00 | 257,696,213.11 | 7,341,486.89 | **97.2** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 28,557,400.00 | 31,424,158.26 | (2,866,758.26) | **110.0** |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 48,963,900.00 | 19,505,404.61 | 29,458,495.39 | **39.8** |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 15,311,500.00 | 14,991,291.00 | 320,209.00 | **97.9** |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 57,114,800.00 | 56,579,865.68 | 534,934.32 | **99.1** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **135,110,700.00** | **134,526,453.71** | **584,246.29** | **99.6** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 68,204,400.00 | 63,879,275.20 | 4,325,124.80 | **93.7** |
| 210302 | Түлш, халаалт | 59,613,300.00 | 52,208,263.51 | 7,405,036.49 | **87.6** |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,293,000.00 | 18,438,915.00 | (11,145,915.00) | **252.8** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **55,987,100.00** | **55,939,190.00** | **47,910.00** | **99.9** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,404,900.00 | 4,404,900.00 | **-** | **100.0** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 40,221,000.00 | 40,221,000.00 | **-** | **100.0** |
| 210403 | Шуудан,холбоо, интернэтийн төлбөр | 3,265,200.00 | 3,217,290.00 | 47,910.00 | **98.5** |
| 210405 | Хог,хаягдал зайлуулах,хортон мэрэгчдийн устгал,ариутгал | 8,096,000.00 | 8,096,000.00 | **-** | **100.0** |
| **2105** | **Нормативд зардал** | **787,250,600.00** | **669,659,414.20** | **117,591,185.80** | **85.1** |
| 210501 | Эм,бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 773,146,200.00 | 655,566,414.20 | 117,579,785.80 | **84.8** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 14,104,400.00 | 14,093,000.00 | 11,400.00 | **99.9** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **38,456,100.00** | **38,456,100.00** | **-** | **100.0** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 2,039,600.00 | 2,039,600.00 | **-** | **100.0** |
| 210604 | Урсгал засвар | 36,416,500.00 | 36,416,500.00 | **-** | **100.0** |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **27,194,100.00** | **26,230,000.00** | **964,100.00** | **96.5** |
| 210702 | Дотоод албан томилолт | 27,194,100.00 | 26,230,000.00 | 964,100.00 | **96.5** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **21,652,500.00** | **21,404,508.17** | **247,991.83** | **98.9** |
| 210801 | Бусад нийтлэг ажил үйлчилгээний хураамж | 195,900.00 | 195,872.17 | 27.83 | **100.0** |
| 210802 | Аудит баталгаажуулалт,зэрэгл эл тогтоох | 5,000,000.00 | 5,000,000.00 | - | **100.0** |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,600,000.00 | 1,488,375.00 | 111,625.00 | **93.0** |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,533,200.00 | 1,506,920.00 | 26,280.00 | **98.3** |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 473,000.00 | 363,000.00 | 110,000.00 | **76.7** |
| 210806 | Мэдээлэл, сурталчилгааны зардал | 5,414,100.00 | 5,414,100.00 | - | **100.0** |
| 210807 | Газрын төлбөр | 6,266,000.00 | 6,265,941.00 | 59.00 | **100.0** |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх зардал | 1,170,300.00 | 1,170,300.00 | - | **100.0** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **87,220,900.00** | **83,382,259.26** | **3,838,640.74** | **95.6** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 73,220,900.00 | 69,382,259.26 | 3,838,640.74 | **94.8** |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 14,000,000.00 | 14,000,000.00 | - | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **236,258,400.00** | **211,739,634.73** | **24,518,765.27** | **89.6** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 236,258,400.00 | 211,739,634.73 | 24,518,765.27 | **89.6** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 228,704,700.00 | 204,185,634.73 | 24,519,065.27 | **89.3** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,553,700.00 | 7,554,000.00 | (300.00) | **100.0** |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **4,851,253,900.00** | **4,829,994,398.27** | **21,259,501.73** | **99.6** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 4,826,622,200.00 | 4,802,103,635.00 | 24,518,565.00 | **99.5** |
| 1200042 | Үндсэн бус үйл ажиллагааны орлого | 24,631,700.00 | 27,890,763.27 | (3,259,063.270 | **113.2** |
| | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | | | | |
| 9001 | Удирдах ажилтан | 3 | 3 | - | **100.0** |
| 9002 | Гүйцэтгэх ажилтан | 93 | 92 | 1 | **98.9** |
| 9003 | Үйлчлэх ажилтан | 14 | 14 | - | **100.0** |
| 9004 | Гэрээт ажилтан | | 1 | -1 | |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *|төгрөгөөр|*

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 2 | **НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН** | - | **589,623,490.77** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | - | **589,623,490.77** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | **589,623,490.77** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл суутгал** | - | **128,005,042.15** |
| 210101 | Үндсэн цалин | - | 19,844,946.15 |
| 210102 | Нэмэгдэл цалин | - | 108,160,096.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | - | **16,935,346.12** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | - | 16,935,346.12 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | - | **9,120,000.00** |
| 210304 | Байрны түрээс | - | 9,120,000.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | - | **67,308,815.00** |
| 210401 | Бичиг хэрэг | - | 3,358,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 63,830,515.00 |
| 210403 | Шуудан,холбоо, интернэтийн төлбөр | - | 120,000.00 |
| 2105 | **Нормативт зардал** | - | **70,861,937.50** |
| 210501 | Эм,бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 30,796,000.00 |
| 210502 | Хоол хүнс | - | 40,065,937.50 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | **9,508,900.00** |
| 210601 | Багаж,техник хэрэгсэл | - | 3,008,900.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 6,500,000.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | - | **164,595,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 164,595,000.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | **123,288,450.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 106,388,450.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 16,900,000.00 |
| 13 | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | **591,902,522.50** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 440,816,777.50 |
| 131103 | ЗГНХ.Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухайн төсвийн захирагчид хуваарилсан | - | 8,075,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 23,634,245.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 119,376,000.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Зоонозын өвчин судлалын үндэсний төв нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо "Зоонозын халдварт өвчнийг тандах, хянах, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг судалгаа, нотолгоонд тулгуурлан мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулж, халдварын эрсдэлийг багасгах замаар хүн амын өвчлөл эндэгдлийг бууруулах"-д оршино гэж тодорхойлсон байна.

Тус төв нь Монгол Улсын хэмжээнд зоонозын халдварт өвчнүүдийг тандах, хянах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг оновчтой зохион байгуулах, зоонозын өвчний тархалтын тандалт судалгааг хийх, хүн амыг халдварт өртөх эрсдэлээс сэргийлэх, зоонозын халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал боловсруулж төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, зоонозын өвчний байгаль дахь тархалт цар хүрээ, идэвхжилийг тогтоож, эрсдэлийн дагуу бүсчлэх, зоонозын өвчний дэгдэлтийн үед голомтод эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг оновчтой зохион байгуулах, орон нутгийн харьяа байгууллагууд болон бусад эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, лабораторийн лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлэх, зоонозын халдварт өвчний мэдээллийн санг бүрдүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн А/171 дүгээр тушаалаар "Зоонозын өвчин судлалын төвийн дэргэдэх эрүүл мэндийн салбарын нөөцийн агуулахын дүрэм"-ийг баталсны дагуу ЭМЯ-аас нөөцийн агуулахын барилга, агуулахад байгаа бараа материалыг 2023 оноос хариуцан ажиллаж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Зоонозын өвчин судлалын үндэсний төв нь Эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн эрүүл мэндийн салбарын бодлогыг зохицуулах, хэрэгжүүлэх үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд голлон мөрдөх дараах хууль, тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон. Тухайлбал:

- Эрүүл мэндийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
- Зөвшөөрлийн тухай хууль;
- Эрүүл мэндийн сайдын 2024 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн А/74 дүгээр тушаалаар баталсан "Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодисыг улсын бүртгэлд бүртгэх журам";
- Сангийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/246 дугаар тушаалаар баталсан "Ерөнхий гэрээний аргаар эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүн худалдан авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг";
- Сангийн сайдын 2024 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн А/118 дугаар тушаалаар баталсан "Нээлттэй тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулах журам";

Удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар судалж, танилцсан бөгөөд дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглахгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Гүйцэтгэх захирлын 2020 оны 01 дүгээр сарын 3-ны өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна.
Тус баримт бичиг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцсэн боловч байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй байна.

Эрүүл мэндийн салбарын нөөцийн агуулах шилжиж ирсэнтэй холбоотойгоор нөөцийн бараа материалын бүртгэл, ангилах, бүртгэх, зарцуулах, зардлын ангилалд нэмэлт өөрчлөлт оруулах, дотоод хяналтын талаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгахаар “Мишээл-од аудит” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааны бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,789,636.5 мянган төгрөгөөр буюу 16.4 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Бараа материал | 8,495,506.2 | 6,311,773.3 | (2,183,732.9) |
| Үндсэн хөрөнгө | 14,675,039.4 | 13,069,135.8 | (1,605,903.6) |
| **Нийт хөрөнгө** | **23,170,545.6** | **19,380,909.1** | **(3,789,636.5)** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо/Эздийн өмч/ | 23,170,545.6 | 19,380,909.1 | (3,789,636.5) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **23,170,545.6** | **19,380,909.1** | **(3,789,636.5)** |

Бараа материал данс нь 6,311,773.3 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 2,183,732.9 мянган төгрөгөөр буурахад худалдаж авсан 898,574.8 мянган төгрөг, Эрүүл мэндийн яамны төрийн нарийн бичгийн даргын тушаалаар эрүүл мэндийн салбарын нөөцийн агуулахад эм, эмнэлгийн хэрэгсэл, материал тоног төхөөрөмж шилжүүлэн өгсөн 5,910,162.9 мянган төгрөг, ХӨСҮТ-өөс болон бусад төсөвт байгууллагаас үнэ төлбөргүй өгсөн 571,587.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, Эрүүл мэндийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу эрүүл мэндийн бусад байгууллагуудад үнэ төлбөргүй шилжүүлсэн 7,956,943.5 мянган төгрөг, эм, эмнэлгийн хэрэгсэлд 181,098.9 мянган төгрөг, лабораторийн хэрэгцээ, тандалт судалгаанд 641,506.9 мянган төгрөг, бичиг хэрэгт 47,747.9 мянган төгрөг, нормын хувцас хамгаалах хэрэгсэлд 1,113.0 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэлд 25,358.6 мянган төгрөг, шатах тослох материалд 82,428.8 мянган төгрөг, барилгын урсгал засварын материалд 31,290.3 мянган төгрөг, бусад аж ахуйн үйл ажиллагаанд 52,856.6 мянган төгрөгийн бараа материал тус тус зарцуулж, ЗӨСҮТ-ийн захирлын 2024 оны А/08, А/55, А/57 дугаар тушаалуудаар акталж данс бүртгэлээс хассан 543,714.0 мянган төгрөг, нийт 9,564,058.5 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө данс 1,605,903.6 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 3,008.9 мянган төгрөг, НҮБ-ын Хүүхдийн сангаас хандивласан 89,100.0 мянган төгрөгийн хөрөнгө */НӨХГ-ын 2024 оны А/447 дугаар тушаалаар/*, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/238, А/251 дүгээр тушаалаар үнэ төлбөргүй шилжүүлсэн тоног төхөөрөмж 424,179.4 мянган төгрөг, тавилга эд, хогшил 11,917.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, НӨХГ-ын даргын 2024 оны А/446 дугаар тушаалаар хөрөнгө актлах шийдвэр гарч 76,252.5 мянган төгрөгөөр хасагдсан байна. Тайлант хугацаанд 2,118,755.4 мянган төгрөгийн элэгдэл байгуулж, хасагдсан үндсэн хөрөнгийн элэгдэл 60,898.3 мянган төгрөг байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 19,380,909.1 мянган төгрөг болж, 3,789,636.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээр буурсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Зоонозын өвчин судлалын үндэсний төв нь 2024 оны төсвийн төсөлд санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсвөөс 4,068,324.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

24,631.7 мянган төгрөг бүрдүүлэхээр, нийт зарлагыг 4,092,956.4 мянган төгрөгөөр тус тус тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн саналыг өөрчлөөгүй 4,092,956.4 мянган төгрөгөөр анх баталсан байна.

Тайлант онд төсөвт 3 удаа тодотгол хийж батлагдсан төсвийг 758,297.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 4,851,253.9 мянган төгрөгөөр баталжээ. Үүнд: цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын зардлыг 391,400.0 мянган төгрөгөөр, ажил олгогчийн төлөх НДШ-ийн зардлыг 55,300.0 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 9,500.0 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 3,000.0 мянган төгрөгөөр, норматив зардлыг 210,097.5 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 15,000.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 9,293.1 мянган төгрөгөөр, бараа, үйлчилгээний бусад зардлыг 66,619.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, эд хогшил, урсгал засварын зардлыг 1,913.0 мянган төгрөгөөр бууруулсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,497,280.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоос 27,890.8 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,525,171.4 мянган төгрөг буюу 93.1 хувьтай байгаа нь цалин хөлс болон ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 178,289.6 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 584.2 мянган төгрөгөөр, хангамж бараа, материалын зардлыг 47.9 мянган төгрөгөөр норматив зардлыг 117,579.8 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 964.1 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 248.0 мянган төгрөгөөр, бараа, ажил үйлчилгээний бусад зардлыг 3,838.6 мянган төгрөгөөр бусад урсгал шилжүүлгийн зардлыг 24,518.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Давсан орлогоос 3,259.2 мянган төгрөг, төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 301,563.7 мянган төгрөг, нийт 304,822.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| Д/Д | Хөтөлбөр арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **1** | **Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ** | **4,851,253.9** | **4,525,171.4** | **326,082.5** | **93.3** |
| 1.1 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 4,614,995.5 | 4,313,431.8 | 301,563.7 | **93.5** |
| 1.2 | Бусад урсгал шилжүүлэг | 236,258.4 | 211,739.6 | 24,518.8 | **89.6** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсвийн гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Ковид-19 цар тахлын эсрэг төслөөс 150,927.1 мянган төгрөг, ДЭМБ-ын төсөл хөтөлбөрөөс 148,550.4 мянган төгрөг, АНУ-ын төсөл хөтөлбөрөөс 57,464.3 мянган төгрөг, НҮБ-ын төсөл хөтөлбөрөөс 83,875.0 мянган төгрөг, буюу нийт 440,816.8 мянган

төгрөгийн санхүүжилт, дээд шатны төсвийн захирагчаас 23,634.2 мянган төгрөг, бусад төсөв байгууллагаас 8,075.5 мянган төгрөг, үйл ажиллагааны хүрээнд бий болсон өөрийн орлого 119,376.0 мянган төгрөг, нийт 591,902.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлснээс үйл ажиллагааны зардалд 589,623.5 мянган төгрөг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 2,279.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 25 багц арга хэмжээнд 837,120.6 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна. Үүнээс нээлттэй тендер шалгаруулалтаар 577,747.5 мянган төгрөгийн, харьцуулалтын аргаар 42,350.0 мянган төгрөгийн, шууд гэрээ байгуулах аргаар 217,023.1 мянган төгрөгийн худалдан авалт хийхээр төлөвлөсөн.
Оношлуур, урвалж, химийн бодис, тэжээлт орчин худалдан авах /20240101001 кодтой/ 366,087.8 мянган төгрөгийн, ариутгал, халдваргүйтгэлийн бодис худалдан авах /20240102001 кодтой/ 128,935.0 мянган төгрөгийн нээлттэй тендер шалгаруулалтыг тус тус зарлаж, гэрээ байгуулж, худалдан авалт хийсэн байна. Ариутгал халдваргүйтгэлийн бодис худалдан авах 26,570.0 мянган төгрөгийн нэг тендерт оролцогч санал ирүүлээгүйн улмаас тендер амжилтгүй болсон. Шууд гэрээ байгуулах аргаар 163,523.8 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

### 3.5.5 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2024 онд нийт 6 төсөл хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ боловсруулах 211,937.1 мянган төгрөгийн төсөл хэрэгжүүлсэн.
2. АНУ-ын Флоридагийн их сургуулийн дэмжлэгээр Монгол орны эктопразит болон эктопразитаар дамжих халдварын үүсгэгчийн тархалтыг тогтоох 57,268.2 мянган төгрөгийн судалгааны ажил хийгдсэн.
3. ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр шувууны томуу өвчний тандалт, хариу арга хэмжээний салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх 100,445.9 мянган төгрөгийн судалгааны ажил хийгдсэн.
4. ДЭМБ-ын дэмжлэгээр Монгол дахь үйланхайт бэтэг өвчний эмнэл зүйн удирдамжийг сайжруулах 48,022.6 мянган төгрөгийн ажил хийгдсэн.
5. ДЭМБ-ын дэмжлэгээр зоонозын халдварын оношилгоо, судалгаанд орчин үеийн молекул биологийн аргуудыг хэрэглэх сэдэвт 58,320.5 мянган төгрөгийн сургалт зохион байгуулагдсан.
6. НҮБ-ын дэмжлэгээр зоонозын тандалтын системийг сайжруулахад хүний нөөцийг чадавхжуулах нь сэдэвт 83,375.0 мянган төгрөгийн сургалт зохион байгуулагдсан.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ХЯЗГААРЛАГДМАЛ САНАЛ ДҮГНЭЛТ

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах талаар мөнгөн хөрөнгийн анхан шатны бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах, бараа материалын үлдэгдлийг баталгаажуулах, эм, эмнэлгийн хэрэгслийн ашиглалтын хугацааг хянах, тооллогыг чанартай гүйцэтгэх, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ингүүмэл жаргалант аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Энхтөр, аудитор Ч.Батсэрээдэнэ нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг Ингүүмэл жаргалант аудит ХХК-ийн аудитын менежер Э.Жаргалмаа, захирал Э.Батчимэг нар, дараагийн шатны хяналтыг Санхүү,нийцлийн аудитын газрын ахлах аудитор М.Пагамдулам, аудитын менежер В.Эрдэнэцогт, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Зоонозын өвчин судлалын үндэсний төв нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1г/58 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 6,590,612.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 65,906.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдан хэрэгжиж байгаатай холбоотойгоор тус төв нь гэрэл, цахилгаан, дулааны зардлыг хэмнэх, гадаад болон дотоод албан томилолтын үр дүнд тавих хяналтыг сайжруулах, давхардуулсан тэтгэмж олгохгүй байх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 584.2 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 964.1 мянган төгрөгөөр, тэтгэмжийн зардлыг 24,518.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 13 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант онд шилэн дансны цахим системд 11,240,086.5 мянган төгрөгийн 260 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2,627,369.2 мянган төгрөгийн дүн бүхий 69 мэдээллийг мэдээлээгүй, 1,688,261.6 мянган төгрөгийн дүн бүхий 60 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Шилэн дансны мэдээний гүйцэтгэл 73.7 хувьтай байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

> <u>Шийдвэрлэсэн нь</u>: Шилэн дансны цахим хуудаст мэдээллийг иж бүрэн, хугацаанд нь мэдээлээгүй зөрчлийг таслан зогсоох, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус төв нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээний жагсаалтыг төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлээгүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ" гэсэн заалттай нийцээгүй байна.

> <u>*Шийдвэрлэсэн нь:*</u> Тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий бараа, ажил, үйлчилгээний жагсаалтыг холбогдох төрийн байгууллагад хүргүүлж ажиллах зөвлөмж өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн ил тод байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт тус тус нийцээгүй гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, цалин, тэтгэмж, өглөг, авлагын дансны хувьд

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

горим сорил хэрэгжүүлсэн. Завсрын аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд мөнгөн бараа материалтай холбоотой 567,165.6 мянган төгрөг, өглөг, авлагатай холбоотой 11,676.0 мянган төгрөг, тэтгэмжтэй холбоотой 200.0 мянган төгрөг нийт 579,041.6 мянган төгрөгийн 5 зөрчил илрүүлж, асуудлын бүртгэлээр зөвлөмж өгсөн ба жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 11,676.0 мянган төгрөгийн алдааг залруулсан байна. Биелэлт хангалтгүй 567,365.6 мянган төгрөгийн 2 зөрчлийг жилийн эцсийн аудитын тайланд тусгасан болно.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 87,311.2 мянган төгрөгийн 4 зөвлөмж, 6,072,749.6 мянган төгрөгийн 6 албан шаардлага өгсөн бөгөөд албан шаардлага, зөвлөмжийг бүрэн биелүүлж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | - | - | - | - | - |
| Албан шаардлага | 6 | 6,072,749.6 | 6 | 6,072,749.6 | 100.0 |
| Зөвлөмж | 4 | 87,311.2 | 4 | 87,311.2 | 100.0 |
| **Нийт дүн** | **10** | **6,160,060.8** | **10** | **6,160,060.8** | **100.0** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг шалгах, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн А/305 дугаар тушаалаар Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дүрэм, бүтцийг баталсан боловч өмчлөлийн хувьд Нийслэлийн өмчийн харилцааны газарт харьяалагдаж байгааг судлах шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 79,309.7 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад залруулсан.

*Залруулсан алдаа:*

- Байгууллагын үйл ажиллагаанд зориулан зарцуулсан 79,294.7 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй гарсан зардлаар бүртгэсэн;
- Үндсэн хөрөнгө данснаас хасаж устгалаас орсон 15.0 мянган төгрөгийн орлогыг үндсэн үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн;

Энэ нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой” гэсэн заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан “Эдийн засгийн ангиллын тайлбар”-тай нийцээгүй, санхүүгийн тайлагналын ангилал, толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй.

Аудитаар нийт 643,642.3 мянган төгрөгийн 9 зөрчил[2] илэрснээс, 602,165.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 7,491.4 мянган төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 1

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

албан шаардлага тус тус хүргүүлж, 33,985.1 мянган төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 639,676.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс их тул **Хязгаарлалттай дүгнэлт** өглөө.

### 5.1 Албан шаардлага

1. Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дэргэдэх Эрүүл мэндийн салбарын нөөцөд байгаа бараанаас 567,165.6 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авах үед хугацаа дууссан үндэслэлээр, мөн ЗӨСҮТ-ийн захирлын 2024 оны А/08 дугаар тушаалаар хугацаа дууссан 37,510.9 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг тус тус акталж устгасан бөгөөд эм, эмнэлгийн хэрэгслийг хугацаа дуусахаас өмнө эргэлтэд оруулах, хугацаанд нь ашиглах арга хэмжээ аваагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалт, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/171 дүгээр тушаалаар баталсан дүрмийн 4.2 "Эрүүл мэндийн салбарын нөөцийн ашиглалтын хугацаанд хяналт тавих, хугацаа дуусахаас өмнө эргэлтэд оруулах, холбогдох байгууллагуудад шилжүүлэх, хугацаа дууссан нөөцийг акталж, устгах үйл ажиллагааг Зоонозын өвчин судлалын үндэсний төв холбогдох журмын дагуу зохион байгуулна" гэсэн заалттай нийцээгүй.

> _Шийдвэрлэсэн нь_: Хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

2. Тайлант онд 29,130.7 мянган төгрөгийн томилолтын зардал, 3,632.1 мянган төгрөгийн интернэтийн төлбөр, 2,041.5 мянган төгрөгийн хэвлэлийн зардал, 195.9 мянган төгрөгийн гаалийн зардлыг тээвэр шатахуун, мэдээлэл, сурталчилгааны зардал, бусад нийтлэг ажил үйлчилгээний зардлаас санхүүжүүлж зарлагын эдийн засгийн ангиллыг зөрчин, зориулалт бус зарцуулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 211 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-тай нийцээгүй.

> _Шийдвэрлэсэн нь_: Зарлагын эдийн засгийн ангиллыг зөрчин, зориулалт бус зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

3. ХӨСҮТ-д 2,299.4 мянган төгрөгийн, Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэгт 5,192.0 мянган төгрөгийн 2 нэр төрлийн хачигт халдварын вакциныг дээд шатны төсвийн захирагчийн шийдвэргүй олгосон байна. Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2023 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн А/305 дугаар тушаалаар баталсан "Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дүрэм"-ийн 3 дугаар зүйлийн 3.2.8 "Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ... зарцуулах үйл ажиллагааг холбогдох шийдвэрийн дагуу зохион байгуулах" гэсэн заалттай нийцээгүй байна.

> _Шийдвэрлэсэн нь_: Бараа материал зөвшөөрөлгүй олгосон буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ХЯЗГААРЛАЛТТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

**Нэмэгдэл хөлстэй холбоотой асуудал**

_1.1.Илрүүлэлт:_
Ажилтан албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгохдоо холбогдох журмыг мөрдөөгүй байна. Тухайлбал: 2024 оны 4-р сард үнэлгээний хуудас, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэр гараагүй байхад нэр бүхий 13 ажилтанд ур чадварын нэмэгдэл олгосон байна. Энэ нь Төвийн захирлын 2023 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн А/38 дугаар тушаалаар баталсан "Ур чадварын нэмэгдэл олгох журам"-тай нийцээгүй байна.

_1.2 Өгсөн зөвлөмж_:
"Ур чадварын нэмэгдэл олгох журам"-ын дагуу үнэлгээний хуудас, дүгнэлтийг хэлэлцэн ажилтан албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох хувийг тогтоох.

**Ажлын цагийн бүртгэлтэй холбоотой асуудал**

_2.1.Илрүүлэлт:_
Ажилтан албан хаагчдын ажлын цаг ашиглалтын бүртгэлийг цаг бүртгэлийн цахим системээр бүртгэж байгаа боловч сарын эцэст ажилтны ажлын цагийн бүртгэлийг системээс хэвлэн авч баталгаажуулаагүй, архивлаагүй байна /НХМаягт ЦХ-1/. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.5 "Ажил олгогч ажилтны ажлын цагийн бүртгэлийг хөтлөх үүрэгтэй", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 11 дүгээр зүйлийн 11.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн баримт болон санхүүгийн тайланг архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол 10-аас доошгүй жил хадгална" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

_2.2.Өгсөн зөвлөмж_:
Ажилтан албан хаагчдын ажлын цаг ашиглалтын бүртгэлд тавих хяналтын сайжруулж, сарын эцэст цаг бүртгэлийн цахим системээс ажлын цагийн мэдээг гаргаж баталгаажуулж, архивлаж байх.

**Тэтгэмжтэй холбоотой асуудал**

_3.1.Илрүүлэлт:_
ЗӨСҮТ-д ажиллаж байсан 2 ахмад настны ар гэрт буцалтгүй тусламж олгохдоо байгууллагын дотоод журамд заасан хэмжээг баримтлаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", байгууллагын дотоод журмын 7.1.4 заалттай нийцээгүй байна.

_3.2.Өгсөн зөвлөмж:_
Байгууллагын дотоод хэм хэмжээг мөрдөж ажиллах, байгууллагын дотоод журмыг нийт ажилтан албан хаагчдад танилцуулж байх.

**Бараа материалтай холбоотой асуудал**

_4.1.Илрүүлэлт:_
Төсвийн хөрөнгөөр ОХУ-аас улсаас худалдан авсан лабораторийн эм, урвалж бодисуудын гаалийн татварт 5,154.6 мянган төгрөг, НӨАТ-ын төлбөрт 10,824.7 мянган төгрөг төлснийг бараа материалын өртөгт шингээж бүртгээгүй, тайлант үеийн зардлаар бүртгэсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.13 заалттай нийцээгүй байна.

*4.2.Өгсөн зөвлөмж:*
Гаалийн зардал болон НӨАТ-ын тооцоог бараа материал, үнэ бүхий зүйлийн өртөгт тооцон бүртгэж байх.

*5.1.Илрүүлэлт:*
Бараа материалын түүвэр тооллогоор 5,002.1 мянган төгрөгийн үнэ бүхий хачигт энцефалитын вакцин, 4,897.9 мянган төгрөгийн үнэ бүхий галзуугийн эсрэг вакцины иммунглобулинг данс бүртгэлгүй байгааг илрүүлсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх"; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.3 "нэр төрлийн материал үнэ бүхий зүйлийн дутагдлыг бусад үнэ бүхий зүйлийн илүүдлээр нэг эд хариуцагчаас гарсан дутагдлыг нөгөө эд хариуцагч дээр гарсан илүүдлээр, хоёр өөр хугацаанд гарсан нэг төрлийн адил үнэтэй зүйлийн дутагдлыг илүүдлээр хаахыг хориглоно. Харин тооллогоор илэрсэн илүүдлийг зохих дансанд орлого болгож илүүдэл гарсан шалтгааныг тогтооно" заалттай тус тус нийцээгүй байна.

*5.2.Өгсөн зөвлөмж:*
Хөрөнгийн тооллогын чанар, гүйцэтгэлийн байдалд тавих хяналтыг сайжруулах, данс бүртгэлгүй хөрөнгийг орлогод авч бүртгэлд тусгах.

*6.1.Илрүүлэлт:*
Нийслэлийн өмчийн харилцааны газрын 2024 оны А/446 дугаар тушаалаар үндсэн хөрөнгө акталж, данснаас хасахаар шийдвэрлэсэн боловч өмчийн харилцааны газарт төвлөрүүлэх хөрөнгөнд үнэлгээ хийгдээгүй, татан төвлөрүүлээгүй байна. Энэ нь Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 66 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.7 "Өмчийн харилцааны газрын дэргэд татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн эд хөрөнгийг татах, сэлбэн засварлах, худалдах үүрэг бүхий нэгж, эд хөрөнгөнд үнэлгээ хийх комисс тус тус ажиллах бөгөөд үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг борлуулалтын орлогоос санхүүжүүлнэ", 4.8 "Хуулийн этгээд нь холбогдох шийдвэрийн дагуу өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад дор үндсэн хөрөнгийг акталж устгах, сэлбэг материал хоёрдогч түүхий эд болгон ашиглах, худалдах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг устгалын акт, эргэлтийн хөрөнгөнд орлого болгосон тэмдэглэл, худалдсан тухай акт хэлбэрээр баталгаажуулан, гүйцэтгэлийн үр дүнг холбогдох данс бүртгэлд тусгана. Худалдан борлуулахдаа нийт ажилчдадаа зарлан мэдээлсний дараа арилжих бөгөөд орлогын 30 хувийг Өмчийн харилцааны газарт төвлөрүүлнэ" гэсэн заалттай нийцээгүй байна.

*6.2.Өгсөн зөвлөмж:*
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож, холбогдох байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | ҮҮНЭЭС | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Байгууллагын үйл ажиллагаанд зориулан зарцуулсан 79,294.7 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй гарсан зардлаар бүртгэсэн байна. | 1 | 79,294.7 | | | 1 | 79,294.7 | 1 | 79,294.7 | | | | |
| Үндсэн хөрөнгө данснаас хасч устгалаас орлогыг үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн байна. | 1 | 15.0 | | | 1 | 15.0 | 1 | 15.0 | | | | |
| **Нийт дүн** | **2** | **79,309.7** | **-** | **-** | **2** | **79,309.7** | **2** | **79,309.7** | **-** | **-** | **-** | **-** |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | ҮҮНЭЭС | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Ажилтан албан хаагчдад ур чадварын нэмэгдэл хөлс олгохдоо холбогдох журмыг мөрдөөгүй байна. Тухайлбал: 2024 оны 4-р сард үнэлгээний хуудас, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэр гараагүй байхад нэр бүхий 13 ажилтанд ур чадварын нэмэгдэл хөлс олгосон байна. | 1 | 3,051.2 | | | | | 1 | 3,051.2 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ЗӨСҮТ-д ажиллаж байсан 2 ахмад настны ар гэрт буцалтгүй тусламж олгохдоо байгууллагын дотоод журамд заасан хэмжээг баримтлаагүй байна | 1 | 200.0 | | | | | 1 | 200.0 | | | | |
| Тайлант онд 29,130.7 мянган төгрөгийн томилолтын зардал, 3,632.1 мянган төгрөгийн интернэтийн төлбөр, 2,041.5 мянган төгрөгийн хэвлэлийн зардал, 195.9 мянган төгрөгийн гаалийн зардлыг тээвэр шатахуун, мэдээлэл, сурталчилгааны зардал, бусад нийтлэг ажил үйлчилгээний зардлаас санхүүжүүлж зарлагын эдийн засгийн ангиллыг зөрчин, зориулалт бус зарцуулсан байна. | 1 | 35,000.2 | | | 1 | 35,000.2 | | | | | | |
| Нийслэлийн өмчийн харилцааны газрын 2024 оны А/446 дугаар тушаалаар үндсэн хөрөнгө акталж, данснаас хасахаар шийдвэрлэсэн боловч өмчийн харилцааны газарт төвлөрүүлэх хөрөнгөнд үнэлгээ хийгдээгүй, татан төвлөрүүлээгүй байна. | 1 | 4,854.6 | | | | | 1 | 4,854.6 | | | | |
| Ажилтан албан хаагчдын ажлын цаг ашиглалтын бүртгэлийг цаг бүртгэлийн цахим системээр бүртгэж байгаа боловч сарын эцэст ажилтны ажлын цагийн бүртгэлийг системээс хэвлэн авч баталгаажуулаагүй, архивлаагүй байна. /НХМаягт ЦХ-1/ | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| ЗӨСҮТ-ийн дэргэдэх Эрүүл мэндийн салбарын нөөцөд байгаа эм, эмнэлгийн хэрэгслийг ашиглалтын хугацаа дуусахаас өмнө хэрхэн яаж эргэлтэд оруулах, холбогдох байгууллагуудад шилжүүлэх, актлах талаар тодорхой журам байхгүй байх | 1 | 567,165.6 | | | 1 | 567,165.6 | | | | | | |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| бөгөөд нөөцийн агуулахаас 567,165.6 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авахад хугацаа дууссан байсан гэх үндэслэлээр акталж устгасан, ЗӨСҮТ-ийн захирлын 2024 оны А/08 дугаар тушаалаар 37,510.9 мянган төгрөгийн хугацаа дууссан вакцин, биобэлдмэлийг актлсан мөн 1,172.6 мянган төгрөгийн хугацаа дууссан 1гр-н тариур агуулахад үлдэгдэлтэй байна. | | | | | | | | | | | | |
| Бараа материалын түүвэр тооллогоор 5,002.1 мянган төгрөгийн үнэ бүхий хачигт энцефалитын вакцин, 4,897.9 мянган төгрөгийн үнэ бүхий галзуугийн эсрэг вакцины иммунглобулинг данс бүртгэлгүй байгааг илрүүлсэн. | 1 | 9,900.0 | | | | | 1 | 9,900.0 | | | | |
| ХӨСҮТ-д 2,299.4 мянган төгрөгийн, Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэгт 5,192.0 мянган төгрөгийн 2 нэр төрлийн хачигт халдварын вакциныг дээд шатны төсвийн захирагчийн шийдвэргүй олгосон байна | 1 | 7,491.4 | | | | | | | 1 | 7,491.4 | | |
| Төсвийн хөрөнгөөр ОХУ-аас улсаас худалдан авсан лабораторийн эм, урвалж бодисуудын гаалийн татварт 5,154.6 мянган төгрөг, НӨАТ-ын төлбөрт 10,824.7 мянган төгрөг төлснийг бараа материалын өртөгт шингээж бүртгээгүй, тайлант үеийн зардлаар бүртгэсэн байна. | 1 | 15,979.3 | | | | | 1 | 15,979.3 | | | | |
| **Нийт дүн** | **9** | **643,642.3** | **-** | **-** | **2** | **602,165.8** | **6** | **33,985.1** | **1** | **7,491.4** | **-** | **-** |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | ҮҮНЭЭС | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | |
| Шилэн дансны цахим системд 2,627,369.2 мянган төгрөгийн 69 мэдээллийг мэдээлээгүй, 1,688,261.6 мянган төгрөгийн 60 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Гүйцэтгэл 73.7%-тай байна. | 1 | 4,315,630.8 | 1 | 4,315,630.8 | | |
| **Нийт дүн** | **1** | **4,315,630.8** | **1** | **4,315,630.8** | **-** | **-** |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | |
| Тус байгууллага тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлээгүй байна. | 1 | - | | | 1 | - |
| **Нийт дүн** | **1** | **-** | **-** | **-** | **1** | **-** |
| **Бүгд дүн** | **2** | **4,315,630.8** | **1** | **4,315,630.8** | **1** | **-** |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 268/2015085 Улаанбаатар хот

СНАГ-2025/196/НА-СТА-ТНЗ

## Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим системд 2,627,369,200.00 */хоёр тэрбум зургаан зуун хорин долоон сая гурван зуун жаран есөн мянга хоёр зуун/* төгрөгийн орлого, зарлагын 69 мэдээллийг мэдээлээгүй, 1,688,261,600.00 */нэг тэр бум зургаан зуун наян найман сая хоёр зуун жаран нэгэн мянга зургаан зуун/* төгрөгийн 60 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ",Төсвийн тухай хуулийн 6.5.3-д “Төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих” гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тоот тушаалаар баталсан“ Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь**:

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн, хугацаанд нь байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн захирал /Б.Амгаланбаяр/, ерөнхий нягтлан бодогч /С.Мөнхчимэг/-д даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР В.ЭРДЭНЭЦОГТ

ИНГҮҮМЭЛ ЖАРГАЛАНТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Э.БАТЧИМЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2025\0225 SNAG-46.Docx

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 266/АО150185 Улаанбаатар хот
СНОТ-2025/196/НА-СТА-ТШ3

## Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн захирлын 2024 оны А/08, А/56, А/57 дугаар тушаалуудаар Эрүүл мэндийн салбарын нөөцийн агуулахаас тайлант онд нийт 567,165,600.00 /*таван зуун жаран долоон сая нэг зуун жаран таван мянга зургаан зуун*/ төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг хугацаа дууссан үндэслэлээр акталж устгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах",Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.6-д “Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх”,Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/171 дүгээр тушаалаар баталсан Эрүүл мэндийн салбарын нөөцийн агуулахын дүрмийн 4.2-д "Эрүүл мэндийн салбарын нөөцийн ашиглалтын хугацаанд хяналт тавих, хугацаа дуусахаас өмнө эргэлтэд оруулах, холбогдох байгууллагуудад шилжүүлэх, хугацаа дууссан нөөцийг акталж, устгах үйл ажиллагааг Зоонозын өвчин судлалын үндэсний төв холбогдох журмын дагуу зохион байгуулна" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тоот тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эм, эмнэлгийн хэрэгслийн ашиглалтын хугацаанд хяналт тавиагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн захирал /Б.Амгаланбаяр/, ерөнхий нягтлан бодогч /С.Мөнхчимэг/-д даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР В.ЭРДЭНЭЦОГТ
ИНГҮҮМЭЛ ЖАРГАЛАНТ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Э.БАТЧИМЭГ

АТА9693 9006109
9023030583

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2025\0225 SNAG-46.Docx

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 267/2015 0185 СНАГ-2025/196/НА-СТА-ПЦ3 Улаанбаатар хот

**Зөрчил арилгах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тээвэр шатахууны зардал, мэдээлэл, сурталчилгааны зардал, бусад нийтлэг ажил үйлчилгээний зардлаас нийт 35,000,198.00 */гучин таван сая нэг зуун ерэн найман/* төгрөгийг зардлын ангилал зөрчиж зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж,тайлагнах", "Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тоот тушаалаар баталсан"Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэсэн заалтыг үндэслэн. **ШААРДАХ нь**:

1. Батлагдсан төсвийг ангилал зөрчиж, зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн захирал /Б.Амгаланбаяр/, ерөнхий нягтлан бодогч /С.Мөнхчимэг/-д даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР — В.ЭРДЭНЭЦОГТ

ИНГҮҮМЭЛ ЖАРГАЛАНТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ — Э.БАТЧИМЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2025\0225 SNAG-46.Docx

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
## АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 265/АО150185 Улаанбаатар хот
СНАГ-2025/196/НА-СТА-ТШЗ

**Сахилгын хариуцлага тооцуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

*Халдварт өвчин судлалын үндэсний төвд 2,299,400.00 /хоёр сая хоёр зуун ерэн есөн мянга дөрвөн зуу/ төгрөг, Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэгт 5,192,000.00 /таван сая нэг зуун ерэн хоёр мянган/ төгрөг, нийт 7,491,400.00/ долоон сая дөрвөн зуун ерэн нэгэн мянга дөрвөн зуун/төгрөгийн 2 нэр төрлийн хачигт халдварын вакциныг дээд шатны төсвийн захирагчийн тушаал шийдвэргүй олгосон байна.*

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.6.2-д"Төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх", Эрүүл мэндийн сайдын 2023 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн А/305 дугаар тушаалаар баталсан "Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дүрэм"-ийн 3 дугаар зүйлийн 3.2.8-д "Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед зарцуулах үйл ажиллагааг холбогдох шийдвэрийн дагуу зохион байгуулах" гэж тус тус заасантай нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42.3-д "Энэ хуулийн 42.1, 42.2-д заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эм, эмнэлгийн хэрэгслийг дээд шатны төсвийн захирагчийн шийдвэргүй олгосон зөрчлийг таслан зогсоох, тархвар судлагч эмч Н.Саранчулуунд сахилгын хариуцлага тооцон, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн захирал /Б.Амгаланбаяр/, ерөнхий нягтлан бодогч /С.Мөнхчимэг/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР В.ЭРДЭНЭЦОГТ
ИНГҮҮМЭЛ ЖАРГАЛАНТ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Э.БАТЧИМЭГ

АТА9693 9006109
6023030583

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр. Утас 51-264230*